



**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах орон тооны бус ШТАБ,
мэргэжлийн ангийг шинэчлэн томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн эрчим хүчний салбарт өгсөн зөвлөмж, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.11.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн хэмжээнд гамшгийн үед ажиллах нөхцөл бололцоог оновчтой, зөв зохион байгуулах зорилгоор Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт ёсоор, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралт ёсоор, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дагаж мөрдөх аюулгүйн ажиллагааны зааврыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн анги нь салбарын алба, техникийн бүлгүүдийг шууд удирдлагаар хангаж, сургаж бэлтгэх, багаж техник, тээврийн хэрэгслээр хангаж, компанийн хэмжээнд гамшиг осол, тоноглолын гэмтэл, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхийг мэргэжлийн ангийн дарга, тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер /Б.Дашдаваа/-д үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүтцийн дагуу ажилтныг томилж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн орлогч дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын байрны дарга, Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Чинбат/-д даалгасугай.

4. Орон нутагт Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор шинэчлэн томилж ажиллахыг Төвийн бүсийн салбарын дарга /Ж.Мөнхжаргал/, Хангайн бүсийн салбарын дарга /П.Баясгалан/, Говийн бүсийн салбарын дарга /С.Намжилцэрэн/, Зүүн-Өмнөд бүсийн салбарын дарга /Н.Мөнгөнхөлөгт/, Улаанбаатар салбарын дарга /Ч.Мөнхпүрэв/ нарт тус тус даалгасугай.

5. Шинэчлэн батлагдсан журмыг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

171201503

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан компанийн гүйцэтгэх захирлын 2019 оны 06 сарын 24-ний өдрийн “Гамшгаас хамгаалах орон тооны бус байнгын албаны бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах орон тооны бус албаны журмыг шинэчлэн батлах тухай” А/154 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.НЯМСАМБУУ



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэгэх захирлын 2020 оны
11... дүгээр сарын 11 ны өдрийн А/192
дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн

Мэргэжлийн ангийн дарга: Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер

Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн:

Ангийн орлогч дарга бөгөөд техникийн
бүлгийн дарга: Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ангийн орлогч дарга бөгөөд санхүү, хангамж хариуцсан
бүлгийн дарга: Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал

Диспетчерийн зохицуулалт, шуурхай ажиллагааны бүлэг:
Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга

Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн:
Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Сэргээн босголтын асуудал хариуцсан бүлэг:
Төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга

Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн:
Мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан бүлэг:
Хяналт мониторингийн хэлтсийн дарга

Санхүү, төсөв хариуцсан бүлэг:
Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Хоол хүнсний хангалт хариуцсан бүлэг:
Нийтлэг үйлчилгээ, тээвэр, механизмын хэлтсийн дарга


Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлэг:
Хүний их эмч

Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн:
Сургалт бүтээмжийн хэлтсийн дарга

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн:
Хуулийн зөвлөх

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны
.11. дүгээр сарын 12. ны өдрийн А/192
дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



КОМПАНИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу "Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги" нь орон тооны бус бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулна.
- 1.2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь болзошгүй аваар саатал, тоноглолын гэмтэл, тасралт, технологийн зөрчил, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, нийтийг хамарсан үймээн самуун, байгалийн гамшиг бусад шалтгаанаар улс, бүс нутгийн хэмжээнд онц байдал зарлах зэргээр онцгой нөхцөл байдал үүссэн үед "ЦДҮС" ТӨХК-ийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, гарсан хор уршгийг арилгах, дахин гаргуулахгүй байх үйл ажиллагааг бүхэлд нь удирдан чиглүүлэх үүрэгтэй.
- 1.3. "Гамшгаас хамгаалах тухай хууль", "Эрчим хүчний тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль", "Зөрчлийн тухай хууль", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм", "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм", "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм", "Эрчим хүчний үйлдвэрт гарсан технологийн зөрчлийг судлан бүртгэх заавар", "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийг мөрдлөг болгож Эрчим хүчний яам бусад хяналтын байгууллагуудын гаргасан шийдвэрүүдийг Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги хэрэгжүүлнэ.
- 1.4. Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь компанийн үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээнд тулгуурласан гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж холбогдох аймаг, дүүргийн онцгой байдлын хэлтэст хянуулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.
- 1.5. Жил бүрийн 1 дүгээр улиралд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэн хянаж, зохих өөрчлөлтийг хийж ажиллана.
- 1.6. Энэ журам нь компанийн бүх салбар, хэсэг, нэгжид нэгэн адил мөрдөгдөнө.
- 1.7. Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь энэхүү журмын хүрээнд үйл ажиллагааны бүтцийн схемээр ажиллах ба "Болзошгүй аваар, саатал, гамшгийн үеийн мэдээллийн схем"-ийн дагуу харилцан мэдээлэл өгнө.

Хоёр. Мэргэжлийн ангийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт

- 2.1 Компанийн төв удирдлага болон орон нутаг дахь салбаруудад тус бүрд нь мэргэжлийн анги байгуулна. Компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын тушаалаар, орон нутаг дахь салбарын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг салбарын даргын тушаалаар томилно.

- 2.2 Компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн даргаар компанийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер, салбарын гамшгаас хамгаалах албаны даргаар салбарын дарга ажиллана. Компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орлогч даргаар Техникийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, салбарын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орлогч даргаар /салбарын/ ерөнхий инженер ажиллана.
- 2.3 Мэргэжлийн ангийн дарга ээлжийн амралт авах, томилолтоор гадаад улсад ажиллах, өвчтэй болон бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй үед мэргэжлийн ангийн орлогч дарга үйл ажиллагааг удирдана.
- 2.4 Компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал, Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хяналт мониторингийн хэлтэс, Шуурхай зохицуулалтын хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс, Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмийн хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга нар ажиллана.
- 2.5 Салбарын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, Захиргаа аж ахуйн алба, Санхүү эдийн засгийн алба, Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба, Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын алба, Засварын алба дарга нар ажиллана.
- 2.6 Салбарын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь үйл ажиллагааны чиглэлээр техникийн бүлэг, хэсэг гэсэн дотоод нэгжтэй байна. Техникийн бүлэг, хэсгүүд нь ахлагч, дэд ахлагч, гишүүдээс бүрдэнэ.
- 2.7 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүлгүүдэд шаардлагатай машин техник, багаж хэрэгсэлийг гүйцэтгэх захирлын тушаалаар батлана.
- 2.8 Тоноглолын их, урсгал засварын ажил хийх, гэмтэл устгах, сольж шинэчлэх зэргээр дэд станц, шугам тоноглолын ашиглалт, засвар хариуцсан техникийн үйл ажиллагаа явуулах гамшгаас хамгаалах албаны нэгжийг "Техникийн бүлэг" гэнэ. Цахилгаан дамжуулах шугамын засвар; Механик; Туршилт; Холбоо; Дэд станцын тоноглолын засвар; Реле хамгаалалт, автоматик; Хэмжүүр; Диспетчерийн зохицуулалт, шуурхай ажиллагааны техникийн бүлгүүдтэй байна.
- 2.9 Компанийн үйл ажиллагаа, технологийн процессийг удирдах, шаардлагатай засвар үйлчилгээ хийх зэрэг техникийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийн ажилд хяналт тавих, /техникийн гэмтэл болон хүмүүсийн үйл ажиллагаанд/ дүгнэлт гаргах, хөдөлмөрийн аюулгүй орчинг бүрдүүлэх, шаардлагатай материал, сэлбэг хэрэгсэл, хоол хүнс, дулаан хувцасаар хангах, санхүү, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, дэд станц, шугам тоноглолын горим ажиллагааг төлөвлөх гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн нэгжийг "Хэсэг" гэнэ. Материал, хангамж; Горим тооцоо; Хоол хүнс; Санхүү; Дотоод хяналт; Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэсгүүдтэй байна.
- 2.10 Техникийн бүлэг, хэсэг бүр нь өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн даргын шууд удирдлагад ажиллана.

- Гурав. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гүйцэтгэх чиг, үүрэг
- 3.1 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн эрх, үүрэг
 - 3.1.1 Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө"-ний дагуу компанийн найдвартай ажиллагааг хангах, болзошгүй аваари саатал, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлэх, гарсан гамшгийн хор хөнөөлийг арилгах, дээд шатны гамшгаас хамгаалах алба, штабын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, онцгой байдал, цагдаа, хүчний байгууллагын мэргэжлийн анги, бүлгээс тусламж авах, цагийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл солилцох үндсэн үүрэгтэй.
 - 3.1.2 Мэргэжлийн анги нь өөрийн нэгж дэх техникийн бүлэг, хэсгүүдэд шаардлагатай багаж төхөөрөмж, автомашин, тээврийн хэрэгсэл, хүн хүч, боловсон хүчнийг бүрдүүлж байнгын бэлэн байдлыг хангаж ажиллана,
 - 3.1.3 Компанийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх, аваари саатлаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй орчинг бүрдүүлэх, ажилтнуудыг сургах, шинэ техник, тоноглол нэвтрүүлэх талаар бодлого, төлөвлөлтийн цогц баримт бичиг боловсруулах, биелэлтэнд хяналт тавих, шаардлагатай өөрчлөлт оруулах, салбарын болон холбогдох яам, засгийн газарт асуудал оруулж шийдвэрлүүлэх
 - 3.1.4 Гамшгаас хамгаалах тухай хууль, компанийн "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө"-ний дагуу болзошгүй аваари саатал, онцгой нөхцөл байдал үүссэн үед бэлэн байдлын зэрэгт шилжүүлж компанийн бүх шатны албан хаагч, ажилтанг дуудаж ажиллуулах эрхтэй.
 - 3.1.5 Техникийн бүлгийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, гадаад улс болон дотоодын сургалтанд хамруулах, сургалтын гарын авлага, шаардлага материалаар хангах үүрэгтэй.
 - 3.2. Мэргэжлийн ангийн даргын эрх, үүрэг
 - 3.2.1 Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг удирдах, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах тодотгохтүүнийг хэрэгжүүлэх талаар гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах
 - 3.2.2 Бие бүрэлдэхүүнийг гамшгийн аюулаас хамгаалах арга дадалд сургах, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед бие бүрэлдэхүүнийг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллах
 - 3.2.3 Байгууллагын эрсдэл ; эмзэг байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
 - 3.2.4 Мэргэжлийн ангийг гамшигтай тэмцэх зориулалтын автомашин техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажлыг байгууллагын төсөвт тусгаж шийдвэрлэх арга хэмжээг авах
 - 3.2.5 Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа албан тушаалтан, иргэнд зааварчилгаа өгөх, хууль ёсны шаардлага тавих, түүнийг биелүүлэхийг шаардах
 - 3.2.6 Мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүнийг батлах, түүний гүйцэтгэх үүргийг тодотгох, байгууллагын нөөц бүрдүүлэх

- 3.2.7 Мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах бэлэн байдал, сэтгэл зүйн бэлтгэл, хэсэг, бүлгүүдийн харилцан шуурхай ажиллах чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөлөөр хангах, бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах
- 3.2.8 Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол үүссэн үед Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон мэргэжлийн байгууллагад шуурхай мэдэгдэх
- 3.2.9 Нутгийн захиргааны болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай харилцан ажиллагааг зохион байгуулах

Дөрөв. Мэргэжлийн ангийн салбар багуудын гүйцэтгэх чиг үүрэг, зориулалт

4.1 Техникийн бүлгийн үүрэг:

- 4.1.1 Техникийн бүлэг, хэсгүүд нь өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хүн хүч, багаж хэрэгсэл, машин техник, тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдлыг хангана. Техникийн бүлгийн дарга нар өдөр тутам бэлэн байдлыг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дутагдалтай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх талаар гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, үйлдвэрлэл техникийн зөвлөлийн болон компанийн захирлын зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлэх үүрэгтэй.
- 4.1.2 Шинэ ажилтныг сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, мэдлэгийн шалгалт авах, компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм заавар, дотоод журмыг биелүүлэн ажиллаж байгаад байнгын хяналт тавина.
- 4.1.3 Техникийн Цахилгаан дамжуулах шугамын засвар; Дэд станцын тоноглолын засвар; Туршилт; Механик; Холбоо; РХА; Хэмжүүрийн бүлгүүдийн нийтлэг үүрэг:
- Дэд станц, шугам тоноглол, бүх төрлийн холбооны төхөөрөмж, автомашин, тээврийн хэрэгсэлд ээлжит болон ээлжит бус эргүүл, үзлэг; төлөвлөгөөт урсгал, их засварын ажлыг цаг хугацаанд нь чанартай хийх
 - Тоноглолын ашиглалтын түвшинг дээшлүүлэх, тэргүүний туршлага, дэвшилтэт техник хэрэгсэл, тоноглол, хамгаалах хэрэгсэл, багажыг нэвтрүүлэх, аварийн нөөц материал бүрдүүлэх талаар холбогдох тооцоо, судалгаа хийж компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, үйлдвэрлэл техникийн зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлэх
 - Бүлгийн гишүүдээс гэрийн жижүүр томилж амралт, баяр ёслолын өдрийг харгалзахгүй жилийн турш ажиллуулах
 - Техникийн бүлгийн гишүүдийн болзошгүй аваар саатал, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд ажиллах дадал туршлагатай болгох. Батлагдсан сэдвийн дагуу “Аваар эсэргүүцэх дасгал”, “Осол эсэргүүцэх дасгал”, “Галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгал”-г нийт бүлгийн гишүүдийг хамруулан чанартай хийх
 - Болзошгүй аваар саатал, гамшгийн хор хөнөөлийг устгах ажилд гамшгаас хамгаалах албаны даргын шийдвэрээр хөдөө орон нутаг, салбарууд, гамшгийн цэгт очиж ажиллах

- Аваар саатал, тоноглолын гэмтэл гарсан үед гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, диспетчерийн зохицуулалт, шуурхай ажиллагааны бүлгийн ахлагч, гишүүдийн дуудсан үед яаралтай ирж гэмтлийг устгах арга хэмжээ авах
- Дэд станц, шугам тоноглолын бүрэн бүтэн байдал, техник ашиглалтын дүрмийн дагуу ашиглалт болон засварын ажил, эргүүл үзлэгийг цаг хугацаанд нь чанартай хийх
- Техникийн бүлгийн ахлагч, гишүүд нь ажлын өдрүүд, гэрийн болон хариуцлагатай жижүүрээр ажиллах боломжгүй болсон, ар гэрийн гачигдал гарсан үед 4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэн гамшгаас хамгаалах албаны даргаас чөлөө авч оронд нь ажиллах хүнийг томилуулна.
- Аваар саатал гарах, тоноглолын гэмтэл устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах явцад өөрийн болон бусад техникийн бүлгийн гишүүдийн хийсэн ажил, тухайн үед үүссэн нөхцөл байдлын талаарх өөрийн гараар бичсэн мэдүүлэг, аваарийн процессийг бүртгэгч аппаратын бичлэг, бусад шаардлагатай баримт бичиг, материалыг аваари, саатал, үйлдвэрлэлийн ослын талаар акт, дүгнэлт гаргаж буй ажилтан болон техникийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэсгийн ахлагч нарт саадгүй гаргаж өгнө.

4.1.4 Диспетчерийн зохицуулалт, шуурхай ажиллагааны бүлгийн үүрэг:

- Компанийн дэд станц, шугам тоноглолын горим, тоног төхөөрөмжийн ажиллагааны байдалд хоногийн 24 цагийн турш тасралтгүй хяналт тавьж, ашиглалтын үед тавигдах шаардлагын дагуу үзлэг, шалгалтыг тогтмол хийлгэж болзошгүй аваари саатал, тоноглолын гэмтлээс урьдчилан сэргийлж ажиллана.
- Тоноглолын их, урсгал засвар, гэмтэл устгах ажлын захиалгыг алба, салбаруудаас авч нэгтгэн графикайн дагуу, шаардлагатай горимын зохицуулалт болон захиалгын боловсруулалтыг хийж гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн даргаар батлуулан гүйцэтгэлд нь хяналт тавих
- Дэд станц, шугам тоноглолд гэмтэл, тасралт сааталд хүргэж болзошгүй хэвийн бус зүйл илэрсэн үед зарлан мэдээлэх схемийн дагуу гамшгаас хамгаалах албаны дарга, техникийн бүлгийн ахлагч, холбогдох хүмүүс, онцгой байдлын газарт мэдэгдэж шуурхай арга хэмжээ авч гэмтэл, хэвийн бус зүйлийг устгуулах
- Тоноглолд урсгал, их засвар, гэмтэл устгах, төсөл шинэчлэлтийн ажил гүйцэтгэх, үзлэг, шалгалт хийх, тоноглолыг засвараас ажилд залгах үед ААД, ТАД-ийг мөрдөж ажиллах. Дүрмийн зөрчил гаргасан, ажлын байранд архидан согтуурсан хүнийг холбогдох техникийн бүлгийн ахлагч, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн даргад мэдэгдэн ажлын байрнаас гаргана.
- Компанийн дэд станц, ИХБ, эзэмшлийн барилга, объектуудыг байнгын хараа хяналтанд байлгаж, хорлон сүйтгэх ажиллагаа, хулгай, халдлага, гал түймэр, гадны хүчин зүйлээс шалтгаалж учирч болзошгүй гамшгаас сэргийлэх
- Аваар саатал, тоноглолын гэмтэл гарч хэрэглэгчид цахилгаан эрчим хүчээр тасалдсан үед схем, тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчдийн ачааллыг шилжүүлэх, тасалж, хязгаарлах, бэлтгэлд байгаа тоноглолыг ажилд залгах, горим ажиллагаанд өөрчлөлт

оруулах зэргээр шаардлагатай арга хэмжээнүүдийг шуурхай ажиллагааны харьцааны зааврын дагуу авч ажиллана.

- Аваар саатал гарах, тоноглолын гэмтэл устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах явцад өөрийн болон бусад техникийн бүлгийн гишүүдийн хийсэн ажил, тухайн үед үүссэн нөхцөл байдлын талаарх өөрийн гараар бичсэн мэдүүлэг, бусад шаардлагатай баримт бичиг (материалыг аваари, саатал, үйлдвэрлэлийн ослын талаар акт, дүгнэлт гаргаж буй ажилтан болон техникийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэсгийн ахлагч нарт саадгүй гаргаж өгнө.
- 4.1.5 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан бүлгийн үүрэг:
- "Гамшгаас Хамгаалах тухай хууль", "Эрчим хүчний тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль", "Зөрчлийн тухай хууль", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм", "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм", "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм" болон компанийн дотоод журам, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн даргын гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үүрэгтэй.
 - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах. Техникийн бүлгийн гишүүд, ажилтнуудыг "Аваари эсэргүүцэх дасгал", "Осол эсэргүүцэх дасгал", "Галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгал"-д хамруулах ажилд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар техникийн бүлгийн ахлагч нарт шаардлага тавих. Дасгалын чанарыг сайжруулах талаар шинэ санаа, санаачлагыг нэвтрүүлэх
 - Техникийн бүлгийн гишүүдийг анх ажилд орох болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд сургах, зааварчилгаа өгөх, давтан сургах
 - Ажлын байр, дэд станц, ИХБ-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2 ба 3 дугаар шатны үзлэгийг явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хөдөлмөрийн аюулгүй, эрүүл орчинг бүрдүүлэх талаар системтэй ажил зохион байгуулна.
 - Дэд станц, ИХБ, ажлын байр, техникийн бүлгүүдийн хөдөлмөр хамгааллын багаж, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, эмийн сан, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлийг ААД-ийн шаардлагын дагуу тогтмол бүрэн хангуулах ажлыг удирдан явуулж, хяналт тавих
 - Өргөх, зөөх машин механизм, хөдөлмөр хамгааллын тусгай багаж, хэрэгслүүдийн ажлын бэлэн байдалд хяналт тавьж, ээлжит хэмжилт туршилтыг хийлгэж байх
 - Ажил гүйцэтгэх үед ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарыг тушаалаар томилон, тэдгээрийн үйл ажиллагаа, нарядын системийн мөрдөлтөнд байнга хяналт тавьж ажиллах
 - Болзошгүй аваар саатал, гэмтэл устгах, төсөл шинэчлэлт, их, урсгал засварын ажлыг хүчдэлтэй нөхцөл, шөнө, гэрэлтүүлэг хангалтгүй, авто зам, хүмүүсийн бөөгнөрөл ихтэй газар, өргөх зөөх машин механизмтай ажиллах болон бусад шаардлагатай үед биечлэн хяналт тавьж, аюулгүй

ажиллагааны зааварчлага өгч үйлдвэрлэлийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх

- Дэд станц, ИХБ, ажлын байраар гэнэтийн эргүүл үзлэг хийж ажилтнуудын хөдөлмөрийн сахилга бат, ээлжийн график мөрдөлтөнд хяналт тавих
 - Дэд станц, ИХБ, агаарын шугамын хамгаалалтын зурвасын дэглэмийг сахиулах, гарч болзошгүй зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх ажлыг системтэйгээр зохион байгуулах. Зөрчил дутагдал илэрсэн нөхцөлд хамгаалалтын зурвасын дэглэмийг сахиулах талаар аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, засаг даргын тамгын газарт мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авахуулах. Зайлшгүй ажлын шаардлагаар эрчим хүчний хамгаалалтын зурваст инженерийн шугам сүлжээ барьж байгуулах, авто замын гарц гаргах, газар шорооны ажил гүйцэтгэх үед холбогдох техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлэх, уг ажлыг гүйцэтгэсний дараа зурвасыг хэвийн байдалд оруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль, дүрэмд заасны дагуу авахуулах
 - Аваар саатал, тоноглолын гэмтэл, дэд станц, шугам тоноглолын хийц хэсгийг эвдэн сүйтгэх, хулгайлах, үйлдвэрлэлийн осол, зөрчил гарсан үед шалтгаан нөхцлийг судалж, акт, дүгнэлт гаргаж, дахин гаргуулахгүй байх талаар сэрэмжлүүлэг мэдээлэл даалгавар гаргах, биелэлтэнд хяналт тавих
 - Аваар саатал, осол, зөрчил гарахад нөлөөлсөн буруутай хүн, техникийн бүлэг, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, дүрэмд заасны дагуу хариуцлага тооцох
 - Хяналт шалгалт, техникийн дүгнэлт, акт гаргахад шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийн хуулбар, Аура, Парма, аваарийн процессийг бичигч төхөөрөмжүүдийн бичлэг, холбогдох ажилтан, техникийн бүлгийн гишүүдээс мэдүүлэг авах
 - Хяналт шалгалт хийх, акт дүгнэлт гаргах, буруутай хүмүүст хариуцлага тооцох, ажилтнуудын мэргэжлийн зэргийг ахиулах зэрэг ажлыг хөндлөнгийн нөлөөнд үл автан үнэн бодитоор тогтоох үүрэгтэй
- 4.1.6 Сэргээн босголтын асуудал хариуцсан бүлгийн үүрэг:
- Компанийн техник, технологи, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техникийн ашиглалт болоод өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, бусад албан хэрэгцээний бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг олон улс болон монгол улс, компанийн хэмжээнд мөрдөж байгаа чанар стандарт, холбогдох хууль, дүрмэнд заасан шаардлагын дагуу /компанийн хэрэгцээнд/ худалдан авах ажлыг зохион байгуулах үндсэн үүрэгтэй.
 - Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгагдсан аваарын нөөц материал, сэлбэг хэрэгсэл болон бусад бараа бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, тэдгээрийн тээвэрлэлт, хадгалалтыг үйлдвэрлэгчийн тавьсан заавар, шаардлагын дагуу хийж чанар, стандартыг мөрдөж ажиллах
 - Бараа бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэлийг хадгалах агуулах, склад, аж ахуйн хашааны харуул хамгаалалт, цоож түгжээ, дохиоллын найдвартай ажиллагаа, галын аюулгүй байдлыг хангах

- Компанид бэлэн байгаа бараа бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй судалгааг сар бүр хийж, өөрчлөлт орох бүрд бүртгэж байх мэдээллийн сантай байх. Болзошгүй аваари саатал, тоноглолын гэмтэл гарах, бэлэн байдал зарлах үед цагийн байдалд хийсэн дүгнэлт, гамшгаас хамгаалах албаны даргын шийдвэрээр аваарийн нөөц материал, сэлбэг хэрэгсэлийг зөөж тээвэрлэх, гамшгийн цэг рүү явуулах ажлыг зохион байгуулах
- Аваар саатал гарч, тоноглолын гэмтлийг устгахад шаардлагатай сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад шаардлагатай бараа, материал компанийн нөөцөд байхгүй нөхцөлд тэдгээрийг хурдан шуурхай олж нийлүүлэх
- Улс оронд онц байдал зарлах, нийтийг хамарсан үймээн, самуун, хорлон сүйтгэх үйл ажиллагаа болж болзошгүй үед компанийн агуулах, склад, аж ахуйн хашаа зэрэгт нэмэлт хамгаалалт авах ажлыг гамшгаас хамгаалах албаны дарга, техникийн бүлгийн гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын газар, цагдаа, хүчний байгууллагаас авах

4.1.7 Санхүү, хангамж хариуцсан бүлгийн үүрэг:

- Санхүү төсөв хариуцсан бүлэг, Хоол хүнсний хангалт хариуцсан бүлэг, Хүн эмнэлэгийн үйлчилгээ хариуцсан бүлэг, Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэнгүүдийг тус тус удирдлагаар хангаж чиглүүлэх үүрэгтэй.

4.1.8 Хоол хүнсний хангалт хариуцсан бүлгийн үүрэг

- Болзошгүй аваари саатал, гэмтэл устгах, онц байдал зарласан бүс нутаг, аймаг, хот, дүүргийн гамшгийн цэгт ажиллаж буй техникийн бүлэг, ажилтнуудыг хоол хүнс, зөөврийн сууц, гэр майхан, өвлийн улиралд халаалт, түлшээр хангах үндсэн үүрэгтэй.
- Гэмтэл, гамшгийн хор хөнөөлийг устгахаар ажиллаж буй техникийн бүлгийн гишүүдийн хоол хүнсийг эрүүл ахуйн шаардлага хангасан цайны газраас авах буюу чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хийх ажлыг зохион байгуулна.
- Болзошгүй аваар саатал, онц байдлын үед гамшгаас хамгаалах албаны даргын шийдвэрээр хөдөө орон нутаг, салбарууд, гамшгийн цэгт очиж ажиллах
- Өвлийн улиралд гамшгийн цэгт ажиллаж буй техникийн бүлгийн гишүүд, ажилтнуудын амрах байр, зөөврийн сууцыг байнгын дулаан байлгах ажлыг хариуцна.

4.1.9 Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан бүлгийн үүрэг:

- Эмнэлэг биологийн халдвар судлалын шинжилгээ хиих, гамшгийн голомтод эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эмчлэн сувилах, халдвар эсэргүүцэх эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх, гамшгийн голомтод эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, олон улсын хөл хориот өвчний дэгдэлт гарсан тохиолдолд халдварт өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах

- Хөдөлгөөнт эмийн сан-эмнэлгийн яаралтай тусламжийн бүлгийн бүрэлдэхүүнд орж, нэрвэгдэгсдийг шаардлагатай эм, тариа, ороох, боох материалаар хангах, цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомтод байсан хүн, техник хэрэгсэлд цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэх

4.1.10 Санхүү, төсөв хариуцсан бүлгийн үүрэг:

- Болзошгүй аваар саатал, гэмтлээс урьдчилан сэргийлэх өдөр тутмын бэлэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг цаг хугацаанд нь шийдвэрлэх
- Компанийн бизнес төлөвлөгөө, зорилтот түвшин, цахилгаан эрчим хүч дамжуулалтын үнэ тарифыг /компанийн/ хэвийн үйл ажиллагаа, техник тоноглолын шинэчлэлтийн бодлого, шаардлагатай засвар, үйлчилгээ хийх, хөрөнгө оруулалт, ТЗБАХ, улс орны эдийн засгийн байдал, бараа үйлчилгээний үнэ, хэтийн төлөвтэй уялдуулан бодитой тогтоох
- Аваар саатал, гэмтлийг устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, онц нөхцөл байдал үүссэн үед шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шуурхай шийдвэрлэх

Тав. Мэргэжлийн ангийн дотоод ажлын зохион байгуулалт

- 5.1 Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь өдөр тутмын техникийн шуурхай, үйлдвэрлэл техникийн зөвлөлийн хурлаар компанийн найдвартай ажиллагааг хангах, их ба урсгал засварын ажлын явц, чанар, техник, технологийн шинэчлэл болон онцгой байдал үүссэн цаг үеийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Аваари, гэмтэл устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, бэлэн байдал зарласан үед ээлжит бус техникийн шуурхай зөвлөлгөөн, хурлыг зарлан хуралдуулна.
- 5.2 Өдөр тутмын техникийн шуурхай, үйлдвэрлэл техникийн зөвлөлийн хурал; ээлжит бус зөвлөлгөөнийг гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга удирдан явуулна.
- 5.3 Техникийн шуурхайд компанийн сүүлийн 24-72 цагийн үйл ажиллагааны байдал, схем тоноглол, горим ажиллагаа, гарсан тасралт, саатал, хийгдсэн болон хийгдэх ажлууд бусад цаг үеийн тулгамдсан асуудлыг диспетчерийн зохицуулалт, шуурхай ажиллагааны бүлгийн ахлагч болон уг бүлгийн гишүүн /ээлжийн диспетчер инженер/ танилцуулж байна.
- 5.4 Техникийн бүлэг, хэсгийн ахлагч нар өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн болон хийгдэх ажлууд, цаг үеийн асуудлуудын талаар мэдээлэл, өөрсдийн санал, дүгнэлтийг танилцуулж байна.
- 5.5 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга техникийн бүлэг, хэсгийн ахлагч нарын мэдээлэл, санал, дүгнэлтийг үндэслэн цагийн байдалд үнэлэлт өгч тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүрэг даалгавар, шийдвэрийг салбарын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, бүлэг, хэсгийн ахлагч нарт өгнө.
- 5.6 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн даргын шийдвэр, үүрэг даалгаврыг техникийн бүлэг хэсгийн ахлагч нар хурдан шуурхай, чанартай биелүүлэх үүрэгтэй бөгөөд биелэлтэнд дотоод хяналтын бүлгийн ахлагч хяналт тавина. Салбаруудынгамшгаас хамгаалах мэргэжлийн анги нь өөрийн салбар, хэсэгт болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гарсан аваар саатал, тоноглолын гэмтлийг устгах ажлыг зохион байгуулна. Гарсан гэмтэл, аваари саатлыг

устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгахад өөрсдийн хүч, техникийн бүлэг, техник, хэрэгсэл, нөөц сэлбэг, тоног төхөөрөмжөөр устгах бололцоогүй үед компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, бусад эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих туслалцаа авч ажиллана.


- 5.7 Салбарт гарсан гэмтлийг устгахад компанийн төв болон бусад байгууллага, ААН-ээс туслалцаа авах, удирдлага, зохион байгуулалтын ажлыг салбарын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, холбогдох техникийн бүлгүүдийн ахлагч нарын санал, дүгнэлтийг үндэслэн компанийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга шийдвэрлэнэ.
- 5.8 Техникийн бүлгийн ахлагч нар өөрсдийн бүлгийн хүн хүч, машин, техник, багаж хэрэгсэлийн бэлэн байдлыг өдөр тутам шалгаж, зөрчил дутагдал илэрсэн үед түүнийг арилгах, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, бүлэг, хэсгийн ахлагч нар нь болзошгүй аваари саатал гарах, гэмтэл устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, бэлэн байдал зарлах үед техникийн бүлэг, хэсгүүдийг шаардлагатай үед баяр ёслол, амралт, хоногийн аль ч үед дуудаж ажиллуулна.

Зургаа. Гамшгаас хамгаалах албаны хүлээх хариуцлага

- 6.1 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн техникийн бүлэг, хэсгийн ахлагч, гишүүд нь холбогдох хууль, засгийн газар, яам, хяналтын байгууллагуудаас гаргасан дүрэм, журам, гамшгаас хамгаалах албаны дүрмийг зөрчиж, ажлын хариуцлага алдсан үед хуулийн дагуу зохих хариуцлагыг хүлээнэ.

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны
... дүгээр сарын ... ны өдрийн ...
дүгээр тушаалын гуравдугаар хавсралт



Гамшгаас хамгаалах мэргэжлийн
ангийн дагаж мөрдөх аюулгүйн
ажиллагааны заавар

1. Мэргэжлийн анги болон түүний дарга нь аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдож, онцгой байдал үүссэн үед гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхдээ энэхүү зааврыг дагаж мөрдөнө.
 - 1.1 Мэргэжлийн ангийн даргын шийдвэр гаргах дараалал:
 - 1.1.1 Мэргэжлийн ангийн дарга нь Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах тухай журам"-ын дагуу бие бүрэлдэхүүнд цугларах дохио өгнө.
 - 1.1.2 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийг хүлээж аваад гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу-бие бүрэлдэхүүнийг заасан газарт техник, багаж хэрэгслийн хамт байрлуулна.
 - 1.1.3 Мэргэжлийн ангийн даргын шийдвэр гаргах дараалал нь гамшгийн цагийн байдал, сургуулийн даалгаврын онцлог, тухайн шатны Засаг дарга болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэрээс шалтгаална.
 - 1.1.4 Мэргэжлийн ангийн дарга гамшгийн цагийн байдлын талаарх мэдээллийг хүлээн аваад тодотгох, нөхцөл байдлыг үнэлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу харилцан ажиллагаа, хангалтыг хэрхэн зохион байгуулах шийдвэрээ бие бүрэлдэхүүнд танилцуулна.
 - 1.2 Мэргэжлийн ангийн даргын шийдвэрт дараах нөхцөл байдлыг тусгана.
 - 1.2.1 Мэргэжлийн ангийн цугларах байр. түүнд хүрэх замын чиглэл, газар зүйн солбилцол, хөдөлгөөн үйлдэх дараалал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой Комиссын байр
 - 1.2.2 Гал түймэр унтраах бүлгийн гал түймэр унтраах багаж хэрэгслийн бүрдэлт, гал түймрийн голомтод очих, буцах зам, бусад хийх ажлын дарааллыг тогтоох
 - 1.2.3 Дайчилгаагаар хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн, гамшигт нэрвэгдэгсдийг цуглуулах талбай, нэрвэгдэгсдийг зөөвөрлөх байр, гамшгийн хязгаарлалтын бүсийн тэмдэглэгээ
 - 1.2.4 Хэзээ, хаана зам гарц гаргах, нураах хийц, аюултай нурангийн талаар тэмдэг тавих, хамгаалалтын ямар ажил хийж гүйцэтгэх, механикжсан бүлгийн хөдөлгөөн үйлдэх зам
 - 1.2.5 Ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, идэвхижил сулруулалт хийх бүс хийгдэх ажлын багтаамж, гүйцэтгэх дараалал, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүлгийн цэвэрлэгээ хийх зам гарц, уусмал цэнэглэж, бэлтгэх байр, саармагжуулсан барилга байгууламжийг тэмдэглэх /халуун, дулаан, хүйтэн бүс/

- 1.2.6 Хээрийн эмнэлгийг дэлгэх газрыг сонгох, нэрвэгдэгсдийг голомтоос татан гаргах, зөөвөрлөх, зам бүртгэлийн ажиллагаа, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, тээвэрлэх боломжгүй өвчтөнд тухайн газарт нь анхны тусламж үзүүлэх, эмнэлгийн бүлгийн хөдөлгөөн үйлдэх замыг тогтоох
- 1.2.7 Химийн хорт болон аюултай бодис тархсан голомтод алдагдсан бодисыг тодорхойлох, үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний авч болох цацраг идэвхэт бодисын дээд, доод хязгаарын тун, хэмжээг тогтоох, ажил эхлэх ба дуусах хугацаа, тархалтыг зогсоох, газар оронд тархахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
- 1.2.8 Харилцан ажиллагааг зохион байгуулахдаа бүлэг, хэсгүүдийн аюулгүй байдалд онцгой анхаарч, гамшгийн зохицуулалтыг шуурхай гүйцэтгэх
- 1.2.9 Мэргэжлийн ангийн дарга нь бүлэг ба гал унтраах бүлгээс мэдээлэл хүлээн авч, нөхцөл байдлыг нарийвчлан тогтоож, дараагийн үүргийг бүлэг, хэсгийн ахлагч нарт хүргэх
- 1.2.10 Нурангид зам гарц гаргах үед гарсан гал түймрийг унтрааж гарц гаргах
- 1.2.11 Гал унтраах бүлэг эхний ээлжинд нэрвэгдэгсэдийг шатаж буй барилгаас аврах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаа явуулахад саад учруулж буй хэсэгт ажиллаж галыг унтраах
- 1.2.12 Цацраг идэвхт бодисоор бохирдсон газар ажиллах хугацааг цацрагийн тун хэмжээ аврагчдын эрүүл мэнд, ажиллах чадварт нөлөөлөхгүй байхаар тооцож ажиллах
- 1.2.13 Ус, дулаан, цахилгаан шугам сүлжээний ослыг илрүүлэх: таслан зогсоох, аюулгүй болгох, аваар техникийн бүлгийн хөдөлгөөн үйлдэх зам дарааллыг тогтоож өгнө.
- 1.3 Мэргэжлийн ангийн дарга цагийн байдлыг үнэлж шийдвэрийг гаргахдаа өөрийн ангийн хүч хэрэгслийн чадавхи, гамшгийн аюулын цар хүрээ, газар, нутгийн онцлог, цаг агаарын байдал зэрэг бүхий л нөхцөл боломжыг бодитойгоор тооцно.
- 1.4 Шийдвэр гаргах үед мэргэжлийн ангийн даргын байр зүйн зурагт бэлэн байх өгөгдөхүүнүүд:
- өөрийн мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн боломж
 - гамшигт өртсөн газар нутгийн хил хязгаарыг харуулах
 - цагийн байдлыг тусгасан мэргэжлийн ангийн байр зүйн зураг
 - мэргэжлийн ангийн эрэн хайх, аврах ажиллагааны бодлогыг харуулсан зураглал (цагийн байдалд тулгуурласан)
- 1.5 Мэргэжлийн ангийн удирдлага нь гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох бүхий л үе шат бүхэнд дараахь үндсэн зарчмуудыг мөрдлөг болгоно.
- Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн байнгын бэлэн байдал; -гамшгаас хамгаалах үйл ажиллагааг, идэвхитэй, тогтвортой, тасралтгүй зохион байгуулах;
- Бусад мэргэжлийн анги, багуудын хоорондын тасралтгүй харилцан ажиллагаа:
- Гэнэт үүссэн гамшгийн цагийн байдалд хариу арга хэмжээг авах;
 - Хүч, хэрэгслийг шийдвэрлэх чухал хэсэг болон чиглэлд шилжүүлэн ажиллуулах
 - Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн хохирлыг дайчилгаагаар ирэх нэмэлт хүч хэрэгслээр нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах
 - Бие бүрэлдэхүүнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх

- 2 Бие бүрэлдэхүүний дагаж мөрдөх аюулгүйн ажиллагааны заавар
 - 2.1 Эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг явуулж байгаа мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн нь аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын төрөл бүрт мөрдөх аюулгүйн ажиллагааны зааврыг чанд сахиж, учирч болох эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах арга дадалд суралцсан байна.
 - 2.2 Мэргэжлийн ангийн удирдлага нь бие бүрэлдэхүүнд гамшгийн голомтын бүс, хил хязгаарыг зааж өгөх, "аюултай" гэсэн тэмдэг, тэмдэглэгээг хаана тавих, аврах хор уршгийг арилгах ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг хэрхэн сахиж ажиллах талаар зааварчилгаа өгч гарын үсэг зуруулна.
 - 2.3 Нэрвэгдэгсдийг голомтоос гаргах зам, гарцыг автомашин, механизм ашиглан урьдчилан байгуулж, тогтоосон замаар нүүлгэнэ. Энэ үед аюултай газрыг тэмдэгжүүлж, хаалт тавина.
 - 2.4 Биологийн аюул тохиолдсон үед ажиллахдаа тусгай хувцас хэрэглэл, хамгаалах өмсгөлөөр хангагдсан тусгайлан бэлтгэгдсэн байх шаардлагатай.
 - 2.5 Аврах ажиллагаанд хэрэглэх техник, багаж хэрэгслийг ажиллуулах дадал чадварыг эзэмшээгүй хүнийг гамшгийн голомт руу нэвтрүүлэхийг хориглоно.
 - 2.6 Цацраг, химийн хорт болон аюултай бодисоор хордсон, гал түймэрт автсан бүс нутагт аюулгүй ажиллагааны зааврыг онцгойлон анхаарах хэрэгтэй.
 - 2.7 Мэргэжлийн анги нь цацраг болон химийн аюултай бодис тархсан гамшгийн голомтод ажиллах хугацаа дууссан эсвэл бие бүрэлдэхүүн цацраг идэвхт бодист хордсон тохиолдолд яаралтай гаргаж, анхны тусламж үзүүлж, дараагийн бүлгийн ажилтнуудыг голомт руу оруулна.
 - 2.8 Аврах үйл ажиллагааны ээлж хүлээлцэхээр ирсэн мэргэжлийн ангийн бүлгийн дарга ээлжээ хүлээлгэн өгөх гэж байгаа бүлгийн даргатай тухайн голомтын гарцан дээр хүлээлцэнэ.
 - 2.9 Хүлээлцэх үед тухайн объектод ажилласан аврах бүлгийн дарга нь ээлж хүлээлцэх үед бүлгийн даргад нөхцөл байдлыг танилцуулж, ээлж солилцох журмыг тохирч, хамтдаа нөхцөл байдлыг шинжилж үзнэ. Мөн голомтын байрлал, сүйрлийн шинж чанар, зэрэглэл, объектод явуулах эрэн хайх, аврах ажил, химийн хорт бодисын болон цацрагийн тунгийн хэмжээ, үүсч болох нөхцөл байдал, хийсэн болон хийх шаардлагатай ажлын талаар мэдээлэл солилцоно. Хүлээлцэж байгаа аврах бүлгийн дарга удирдах бүрэлдэхүүний байрлаж байгаа газар, тэдэнтэй холбоо барих журмыг мэдүүлсэн байна.
 - 2.10 Эвдэрч сүйрсэн байгууламж, хийн болон тэсэрч дэлбэрэх, гал гарах аюултай объектод байгаа аврах бүлгийн бие бүрэлдэхүүнд аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт баримтлах аюулгүй ажиллагааны баримтлах зааврыг дагаж мөрдөх талаар зөвлөмж өгнө.
 - 2.11 Мэргэжлийн ангийн аврах бүлгийг гамшгийн голомтоос гарсны дараа амраах, шаардлагатай бол дараагийн ажиллагаанд бэлтгэж, багаж болон хамгаалалтын хувцас, хэрэгслийг сольж, устгалд оруулах, ажилласан багаж, хэрэгсэлд техникийн үйлчилгээ хийх, ариутгах, нөхөн бүрдүүлэх арга хэмжээг авна.
 - 2.12 Халдварт өвчний голомтод үүрэг гүйцэтгэх аврах бүлгийн хөдөлмөр хамгааллын хувцас, ажиллах багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд багаж хэрэгсэл дээр ажиллах дадлагыг эзэмшсэн байна.